МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/143 Мөрөн сум

Цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын "Ухаан Далай" хүүхдийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчийн шийдвэр, хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дүгээр захирамжаар олгосон сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

2. Тус цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан холбогдох бүртгэлээс зохих журмын дагуу хасахыг Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН